# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 07 дугаар сарын 08
№ 26 (1224)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠲᠥᠷᠥ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

# ГАРЧИГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


479. Донорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1907

480. Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай 1909

481. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 1910

482. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай 1911

483. Монгол Улсын батлан хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1912

484. Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай 1913

485. Цэргийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1914


## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ


486. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Дугаар 40 1915


## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ


487. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 37 1916

488. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 38 1916


## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


489. Журам шинэчлэн батлах тухай Дугаар 2 1917


## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ


490. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн талаарх зохицуулалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг дахин хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 01 1944

# ᠭᠠᠷᠴᠠᠭ

## ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

| | | | |
|---|---|---|---|
| ᠔᠘᠙ · | [illegible] ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠂ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ | | ᠑᠙᠐᠘ |
| ᠔᠗᠐ · | [illegible] [illegible] ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ | | ᠑᠙᠐᠙ |
| ᠔᠗᠑ · | [illegible] ᠶᠢᠨ [illegible] ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠂ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ | | ᠑᠙᠑᠐ |
| ᠔᠗᠒ · | [illegible] ᠶᠢᠨ [illegible] ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠲᠠᠢ ᠬᠠᠮᠲᠤ ᠳᠠᠭᠠᠯᠳᠤᠭᠤᠯᠬᠤ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ | | ᠑᠙᠑᠑ |
| ᠔᠗᠓ · | ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ [illegible] [illegible] ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠂ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ | | ᠑᠙᠑᠒ |
| ᠔᠗᠔ · | [illegible] [illegible] ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ | | ᠑᠙᠑᠓ |
| ᠔᠗᠕ · | [illegible] ᠤᠨ [illegible] ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠂ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ | | ᠑᠙᠑᠔ |

## ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ

| | | | |
|---|---|---|---|
| ᠔᠗᠖ · | ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢ ᠬᠢᠨᠠᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ | ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠔᠐ | ᠑᠙᠑᠕ |

## ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠷᠦᠩᠬᠡᠶᠢᠯᠡᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠵᠠᠷᠯᠢᠭ

| | | | |
|---|---|---|---|
| ᠔᠗᠘ · | [illegible] ᠶᠢᠨ [illegible] [illegible] ᠶᠢᠨ [illegible] ᠲᠤᠬᠠᠢ | ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠓᠖ | ᠑᠙᠑᠖ |
| ᠔᠗᠗ · | [illegible] ᠶᠢᠨ [illegible] [illegible] ᠶᠢᠨ [illegible] ᠲᠤᠬᠠᠢ | ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠓᠗ | ᠑᠙᠑᠖ |

## ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ

| | | | |
|---|---|---|---|
| ᠔᠗᠙ · | [illegible] [illegible] ᠪᠠᠲᠤᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ | ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠒ | ᠑᠙᠑᠘ |

## ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ [illegible] [illegible] ᠶᠢᠨ [illegible] ᠶᠢᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ

| | | | |
|---|---|---|---|
| ᠔᠙᠐ · | [illegible] ᠶᠢᠨ [illegible] ᠤᠨ [illegible] ᠳᠤ [illegible] [illegible] [illegible] ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ [illegible] ᠳᠤ [illegible] [illegible] ᠲᠤᠬᠠᠢ | ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠐᠑ | ᠑᠙᠔᠔ |

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

## ДОНОРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Донорын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/7 дугаар зүйлийн 7.1.7, 7.1.8 дахь заалт:**

"7.1.7.Цусны болон эс, эд, эрхтний донорын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан байгуулах, сангийн ажиллах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах;

7.1.8.цусны болон эс, эд, эрхтний амьд донорыг тухайн эзний зөвшөөрлийг үндэслэн олон нийтэд таниулах, алдаршуулах, амьгүй донор болон түүний гэр бүлд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийг үндэслэн зохион байгуулах;"

**2/7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг:**

"7.2.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах асуудлаар мэргэжил, ёс зүйн хороо ажиллана. Тус хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

**2 дугаар зүйл.**Донорын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн "цусаа" гэсний өмнө "амьд донор болон" гэж, мөн зүйлийн 22.2 дахь хэсгийн "Цусны" гэсний дараа "байнгын болон амьд" гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Донорын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалтын дугаарыг "7.1.9" гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн "25 насанд" гэснийг "21 насанд" гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийн 2 дугаар зүйлийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

᠒᠐᠒᠒ ᠣᠨ ᠤ ᠐᠖ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠑᠔-ᠨ ᠦ ᠡᠳᠦᠷ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

## ᠬᠦᠨᠡᠰᠦ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ᠂ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠬᠦᠨᠡᠰᠦ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠳᠣᠣᠷ᠎ᠠ ᠳᠤᠷᠠᠳᠤᠭᠰᠠᠨ ᠠᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠲᠠᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠨᠡᠮᠡᠭᠰᠡᠭᠡᠢ᠄

᠑/ ᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠔.᠑.᠔, ᠔.᠑.᠗ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ᠄

« ᠔.᠑.᠔. [illegible] »

« ᠔.᠑.᠗. [illegible] »

᠒/ ᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠔.᠑.᠑᠐ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ᠄

« ᠔.᠑.᠑᠐. [illegible] »

᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠬᠦᠨᠡᠰᠦ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠒᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠒᠒.᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ « [illegible] » ᠭᠡᠰᠡᠨ ᠦ ᠬᠣᠢᠨ᠎ᠠ « [illegible] » ᠭᠡᠵᠦ ᠨᠡᠮᠡᠭᠰᠡᠭᠡᠢ᠃

᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠬᠦᠨᠡᠰᠦ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠔.᠑.᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ « ᠖.᠑.᠔ » ᠭᠡᠰᠡᠨ ᠢ « ᠔.᠑.᠕ » ᠭᠡᠵᠦ᠂ ᠑᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑᠓.᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ᠂ ᠑᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑᠔.᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ « ᠒᠘ ᠵᠦᠢᠯ ᠳᠦ » ᠭᠡᠰᠡᠨ ᠢ « ᠒᠙ ᠵᠦᠢᠯ ᠳᠦ » ᠭᠡᠵᠦ ᠲᠤᠰ ᠲᠤᠰ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠭᠰᠡᠭᠡᠢ᠃

᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠒᠐᠒᠓ ᠣᠨ ᠤ ᠐᠑ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠑-ᠨ ᠦ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠡᠨ᠎ᠡ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠭ᠂ ᠵᠠᠩᠳᠠᠨᠱᠠᠲᠠᠷ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Эрүүл мэндийн тухай хуулийн 26 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 26.5 дахь хэсэг нэмсүгэй:

“26.5.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах асуудлаар мэргэжил, ёс зүйн хороо ажиллана. Тус хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Донорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

ᠬᠣᠲᠠ 2022 ᠣᠨ ᠤ 06 ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ 17 — ᠨᠤ ᠡᠳᠦᠷ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ

ᠡᠷᠡᠭᠦᠯ ᠮᠡᠨᠳᠦ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

1 ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠡᠷᠡᠭᠦᠯ ᠮᠡᠨᠳᠦ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ 26 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠳᠦ ᠳᠣᠣᠷ᠎ᠠ ᠳᠤᠷᠠᠳᠴᠤ ᠪᠤᠢ ᠠᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠲᠠᠢ 26.5 ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠨᠡᠮᠡᠰᠦᠭᠡᠢ᠄

《26.5. ᠡᠷᠡᠭᠦᠯ ᠮᠡᠨᠳᠦ ᠶᠢᠨ ᠠᠰᠠᠭᠤᠳᠠᠯ ᠡᠷᠬᠢᠯᠡᠭᠰᠡᠨ ᠲᠥᠷᠥ ᠶᠢᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠵᠠᠬᠢᠷᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠥᠪ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠳᠡᠷᠭᠡᠳᠡ ᠡᠰ᠂ ᠡᠳ᠂ ᠡᠷᠬᠡᠲᠡᠨ ᠰᠢᠯᠵᠢᠭᠦᠯᠦᠨ ᠰᠠᠭᠤᠯᠭᠠᠬᠤ ᠠᠰᠠᠭᠤᠳᠠᠯ ᠢᠶᠠᠷ ᠮᠡᠷᠭᠡᠵᠢᠯ᠂ ᠶᠣᠰᠤ ᠵᠦᠢ ᠶᠢᠨ ᠬᠣᠷᠢᠶ᠎ᠠ ᠠᠵᠢᠯᠯᠠᠨ᠎ᠠ᠃ ᠲᠤᠰ ᠬᠣᠷᠢᠶ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠳᠦᠷᠢᠮ᠂ ᠪᠦᠷᠢᠯᠳᠦᠬᠦᠨ ᠢ ᠡᠷᠡᠭᠦᠯ ᠮᠡᠨᠳᠦ ᠶᠢᠨ ᠠᠰᠠᠭᠤᠳᠠᠯ ᠡᠷᠬᠢᠯᠡᠭᠰᠡᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠭᠡᠰᠢᠭᠦᠨ ᠪᠠᠲᠤᠯᠠᠨ᠎ᠠ᠃》

2 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠳᠣᠨᠣᠷ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ᠂ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠡᠷ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠥᠳᠡᠨ᠎ᠡ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠭ᠂ ᠵᠠᠨᠳᠠᠨᠱᠠᠲᠠᠷ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

## ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 167 дугаар зүйлийн 167.2 дахь хэсгийн “болсон” гэснийг “болж, ялтанд цахим бугуйвч зүүлгэсэн” гэж, 257 дугаар зүйлийн 257.1 дэх хэсгийн “төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий” гэснийг “тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн” гэж, 270 дугаар зүйлийн 270.7 дахь хэсгийн “Цагдан хорих” гэснийг “Баривчлах болон цагдан хорих” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр — Улаанбаатар хот

## ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд “2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл шийдвэр гүйцэтгэгчээр энгийнээр ажилласан хугацааг цэргийн албанд ажилласан хугацаанд тооцох бөгөөд энэ зохицуулалтад 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө цэргийн алба хаасны тэтгэвэр болон өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан иргэнд хамаарахгүй.” гэсэн хоёр дахь өгүүлбэр нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “дотоодын цэрэг,” гэсний дараа “шүүхийн шийдвэр гүйцэтгэх,” гэж, 9.3 дахь хэсгийн “дотоодын цэргийн командлагч,” гэсний дараа “шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дарга,” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтын “хил хамгаалалтын” гэснийг “хил хамгаалалт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зэвсэгт хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “дотоодын цэрэг,” гэсний дараа “шүүхийн шийдвэр гүйцэтгэх,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

## ЦЭРГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Цэргийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “дотоодын цэрэг,” гэсний дараа “шүүхийн шийдвэр гүйцэтгэх,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Цэргийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсгийн “хил хамгаалалтын” гэснийг “хил хамгаалалт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 40 | Улаанбаатар хот |

**Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндсийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 85 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”-ийн 7.1, 7.3, 7.4, 7.8 дахь заалтын “дотоод цэрэг,” гэсний дараа “шүүхийн шийдвэр гүйцэтгэх,” гэж, 7.9 дэх заалтын “дотоодын цэргийн командлагч,” гэсний дараа “шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дарга,” гэж тус тус нэмсүгэй.

2.Энэ тогтоолыг 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 37 | Улаанбаатар хот

**Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 6 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах эрх үүсэж, өөрөө хүсэлтээ гаргасан Ёндонгийн Цогтзанданг Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 38 | Улаанбаатар хот

**Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 54 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах эрх үүсэж, өөрөө хүсэлтээ гаргасан Готовын Уламбаярыг Баянхонгор аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ**

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр | Дугаар 2 | Улаанбаатар хот

**Журам шинэчлэн батлах тухай**

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг хавсралт ёсоор батлсугай.

2.Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Сангийн сайд Б.Жавхлан, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2014 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 43 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД Н.УРТНАСАН**

Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын хавсралт

## БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ХЭСГИЙГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.1-д заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг (цаашид “төлбөрийн орлогын хэсэг” гэх) байгалийн ургамал, ан амьтан, газар, ус, рашаан, ойн нөөц ашигласны

төлбөрийн орлогоос бүрдүүлэх, төсвийн суурь зарлагад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг тусгах, зарцуулах, тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Төлбөрийн орлогын хэсгийг төлөвлөх, тайлагнахад энэ журмын хавсралт маягтуудыг (цаашид “БНАТ маягт” гэх) ашиглах бөгөөд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35.1.17-д заасан Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн санд цахимаар байршуулна.

**Хоёр.Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх**

2.1.Төсвийн жилийн төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 1.2-т заасан орлогоос Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээ болон түүнээс дээш хэмжээгээр бүрдүүлнэ.

2.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэртээ холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний талаарх саналаа жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.3.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 2.2-т заасан саналыг хянан, ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг тогтоож, жил бүрийн 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

2.4.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмын 2.3-т заасныг үндэслэн ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг жил бүрийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор сум, дүүрэг тус бүрээр тогтооно.

2.5.Сум, дүүргийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 23.8.4, 23.8.6, 23.8.7, 23.8.9, 23.8.14-т заасан орлогын төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-1 маягтын дагуу жил бүрийн 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

2.6.Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасан орлогын төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-3 маягтын дагуу жил бүрийн 7 дугаар сарын 25-ны өдрийн дотор боловсруулна.

2.7.Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага энэ журмын 2.5, 2.6-д заасан нийт орлогын төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-5 маягтын дагуу нэгтгэж, аймаг, нийслэлийн төсвийн саналд тусгуулахаар жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор тухайн шатны Засаг даргад хүргүүлнэ.

**Гурав.Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт**

3.1.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаартай тэнцэх төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна.

3.2.Энэ журмын 3.1-д зааснаас бусад төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг харгалзахгүйгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна.

3.3.Энэ журмын 3.1-д заасан нөхцөл, хязгаарыг хангаагүй тохиолдолд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоор орон нутгийн төсвийн суурь зарлагыг санхүүжүүлэхгүй.

3.4.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ журмын 1.2-т заасан орлогын хэмжээнд үндэслэн төсвийн жилийн суурь зарлагын төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна:

3.4.1.байгалийн ургамлыг хамгаалах, доройтсон бэлчээрийн газрыг нөхөн сэргээх арга хэмжээ;

3.4.2.аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагын саналыг үндэслэн аймгийн агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ;

3.4.3.аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага болон ойн ангийн саналыг үндэслэн аймаг, сум, нөхөрлөлийн ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ;

3.4.4.аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага болон усны сав газрын захиргааны саналыг үндэслэн сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ;

3.4.5.тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа болон менежмент хариуцагч хуулийн этгээдийн саналыг үндэслэн улсын болон орон нутгийн хамгаалалттай газар нутгийн, орчны бүсийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан газрын нөхөн сэргээлт.

3.5.Энэ журмын 3.4-т заасныг үндэслэн төлбөрийн орлогын хэсгээр тухайн аймаг, нийслэлийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих дараах арга хэмжээний зардлыг санхүүжүүлнэ:

3.5.1.хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдлын судалгаа хийх;

3.5.2.хөрсний доройтол, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, сааруулах, хамгаалах, тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах;

3.5.3.хүчтэй, нэн хүчтэй доройтсон хөрсийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр чадавхыг бэхжүүлэх;

3.5.4.ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгаа хийх;

3.5.5.аймгийн агнуурын менежментийн төлөвлөгөө болон нэн ховор, ховор амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.5.6.ой зохион байгуулалтын ажил, ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

3.5.7.ой, хээрийн түймэр, хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

3.5.8.ойг нөхөн сэргээх, үржүүлэх ажлыг жил бүр зохион байгуулж, түүний биелэлтэд хяналт тавих;

3.5.9.иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр бойжуулсан чанартай тарьц, суулгац, тарьсан мод, бут, сөөг, таримал ойг зохих журмын дагуу худалдан авах, нөхөн сэргээсэн ойг бусад хэлбэрээр урамшуулах;

3.5.10.усны тоо бүртгэл явуулж, усны мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах;

3.5.11.усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, хуримтлуулах, усан орчинг нөхөн сэргээх, үерийн аюулаас урьдчилан

сэргийлэх, усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлэх, бүсийн дэглэмийг мөрдүүлэх, усны бохирдлыг арилгах, нөхөн сэргээх;

3.5.12.байгалийн нөөц газар, дурсгалт газар, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

3.5.13.энэ журмын 3.5.1-3.5.12-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих томилолтын зардлыг санхүүжүүлэх.

3.6.Энэ журмын 3.4-т заасныг үндэслэн төлбөрийн орлогын хэсгээр, энэ журмын 3.5.6, 3.5.7, 3.5.8-д зааснаас гадна тухайн сум, дүүргийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих дараах арга хэмжээний зардлыг санхүүжүүлнэ:

3.6.1.энэ журмын 3.5.1, 3.5.2-т заасан судалгаа, үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн хөрсний доройтол, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, сааруулах, хамгаалах, тэмцэх ажлыг хэрэгжүүлэх;

3.6.2.хүчтэй, нэн хүчтэй доройтсон бэлчээрийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх;

3.6.3.байгалийн ургамлыг гал түймэр, өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах, нөхөн сэргээх;

3.6.4.амьтны амьдрах орчныг сайжруулах, өсгөн үржүүлэх, нэн ховор, ховор амьтанд зориулж худаг гаргах, биотехникийн арга хэмжээ авах;

3.6.5.ахуйн болон тусгай зориулалтын агнуурын үйл ажиллагаанд хяналт тавих, хууль бус агнуур, худалдаанаас урьдчилан сэргийлэх;

3.6.6.хуурайшилтын улирал эхлэхээс өмнө ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх аян зохион байгуулах;

3.6.7.ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх, сайн туршлагыг нэвтрүүлэх;

3.6.8.цөлжилтийг сааруулах зорилгоор ойн зурвас байгуулах;

3.6.9.ойн нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.6.10.гол, горхи, уст цэгийн тооллого явуулах, усны мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ;

3.6.11.усны хамгаалалтын бүс тогтоох, тэмдэгжүүлэлт хийх;

3.6.12.булаг, шанд, усны эхийг хамгаалах, гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх;

3.6.13.ус, рашаан хамгаалах, усны чанарын төлөв байдалд шинжилгээ хийх;

3.6.14.орон нутгийн хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

3.6.15.улсын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө, орчны бүсийн менежментийн төлөвлөгөөнд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.6.16.нутаг дэвсгэртээ идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах, ажлын үр дүнгээр урамшуулах, байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах талаарх нутгийн иргэдийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах;

3.6.17.байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлтэй байгуулсан гэрээг хэрэгжүүлэх;

3.6.18.энэ журмын 3.6.1-3.6.17-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх хяналт тавих томилолтын зардлыг санхүүжүүлэх.

3.7.Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.5, 3.6-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно.

3.8.Сум, дүүргийн Засаг дарга энэ журмын 3.6-д заасан арга хэмжээний төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-2-А маягтын дагуу боловсруулж, жил бүрийн 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

3.9.Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага энэ журмын 3.5-д заасан арга хэмжээний төлөвлөгөөг энэ

журмын хавсралт БНАТ-4-А маягтын дагуу жил бүрийн 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор боловсруулна.

3.10.Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага энэ журмын 3.8, 3.9-д заасан нийт арга хэмжээний төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-6-А маягтын дагуу нэгтгэж аймаг, нийслэлийн төсвийн саналд тусгуулахаар жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

3.11.Сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-2-Б маягтын дагуу жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

3.12.Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-4-Б маягтын дагуу жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор боловсруулна.

3.13.Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага энэ журмын 3.11, 3.12-т заасан нийт арга хэмжээний төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-6-Б маягтын дагуу жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор нэгтгэнэ.

3.14.Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага энэ журмын 3.9, 3.12-т заасан арга хэмжээний нэгтгэл төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-4 маягтын дагуу, энэ журмын 3.10, 3.13-т заасан арга хэмжээний төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-6 маягтын дагуу тус тус нэгтгэж, төсвийн төсөлд тусгуулахаар жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор тухайн шатны Засаг даргад хүргүүлнэ.

3.15.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ журмын 3.14-т заасан арга хэмжээний нэгтгэл төлөвлөгөөг төсвийн төсөлд тусган жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

3.16.Сум, дүүргийн Засаг дарга энэ журмын 3.8, 3.11-т заасан арга хэмжээний төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-2 маягтын дагуу нэгтгэж, төсвийн төсөлд тусган жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

3.17.Байгалийн ургамал, амьтны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, байгаль орчны мэргэжлийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

3.18.Ус, рашааны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг усны сав газрын захиргаатай хамтран хэрэгжүүлнэ.

3.19.Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг сум дундын ойн анги, ойн нөхөрлөл, байгаль орчны мэргэжлийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

3.20.Газрын нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, бэлчээр ашиглагчдын хэсэг, бүлэг, малчид, ойн нөхөрлөл, орчны бүсийн зөвлөлтэй хамтран хэрэгжүүлнэ.

**Дөрөв.Төлбөрийн орлогын хэсгийг тайлагнах, хяналт тавих**

4.1.Сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны төсөвт төвлөрүүлсэн төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтын тайланг энэ журмын хавсралт БНАТ-7, БНАТ-8 маягтын дагуу боловсруулж жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад тус тус хүргүүлнэ.

4.2.Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага тухайн шатны төсөвт төвлөрүүлсэн төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтын тайланг энэ журмын хавсралт БНАТ-9, БНАТ-10 маягтын дагуу боловсруулж жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор нэгтгэнэ.

4.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ журмын 4.1, 4.2-т заасан тайланг энэ журмын хавсралт БНАТ-11, БНАТ-12 маягтын дагуу нэгтгэж жил бүрийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ.

4.4.Энэ журмын 4.3-т заасан тайланг Байгаль хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн санд бүрэн оруулсан эсэхэд

байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

4.5.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 4.3-т заасан тайланд үндэслэн энэ журмын 2.3-т заасан ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээнд өөрчлөлт оруулах эсэхийг шийдвэрлэнэ.

4.6.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэл, сум, дүүргийн байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад жил бүр санхүүгийн дотоод аудит, хяналт-шинжилгээ хийнэ.

4.7.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үнэлгээ хийнэ.

4.8.Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээ, зарцуулах төсвийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хийх гэрээнд шалгуур үзүүлэлт бүрээр тусгана.

4.9.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтыг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан өдөр тутмын болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын албан ёсны цахим хуудсаар олон нийтэд түгээнэ.

4.10.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн жилийн байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний төсвийн орлогын хэсгийг бүрдүүлэх, төлөвлөх, зарцуулах, хянах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангана.

4.11.Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих, мэдээлэл авах боломжийг аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүрдүүлнэ.

---o0o---

# Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын 1 дүгээр хавсралт

Маягт БНАТ-1

................................ АЙМГИЙН / НИЙСЛЭЛИЙН................................ СУМЫН / ДҮҮРГИЙН......... ОНЫ ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ
БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Санамж:** Сум, дүүргийн байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, усны сав газрын захиргаа, сум дундын ойн анги, татварын улсын байцаагч, сум, дүүргийн газрын даамал нар хамтран боловсруулна. Жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор Байгаль орчныг хамгаалах төсөв, зардлын мэдээллийн санд байршуулж, аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагад маягтаар хүргүүлнэ.

| № | Нөөц | Төлбөр ногдох зүйл | Нэр, төрөл | | Байршил | Төлбөр ногдуулах үндэслэл | | | Төлбөрийн орлого бүрдүүлэлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Менежментийн төлөвлөгөө | ИТХ-ын тогтоол | Бусад | Хэмжих нэгж | Нэгжийн төлбөр | Тоо хэмжээ | Нийт орлого, төгрөгөөр |
| | А | Б | В | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | Байгалийн ургамал | 1.1. Нэн ховор ургамал | 1.1.1 | | | | | | | | | |
| | | | 1.1.2 | | | | | | | | | |
| | | | 1.1.3 | | | | | | | | | |
| | | 1.2. Ховор ургамал | 1.2.1 | | | | | | | | | |
| | | | 1.2.2 | | | | | | | | | |
| | | | 1.2.3 | | | | | | | | | |
| | | 1.3. Элбэг ургамал | 1.3.1 | | | | | | | | | |
| | | | 1.3.2 | | | | | | | | | |
| | | | 1.3.3 | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | *Нийт:* | |
| 2 | Ан амьтан | 2.1. Ахуйн зориулалтаар агнах, барих | 2.1.1 | | | | | | | | | |
| | | | 2.1.2 | | | | | | | | | |
| | | | 2.1.3 | | | | | | | | | |
| | | 2.2. Үйлдвэрлэлийн зориулалтаар агнах, барих | 2.2.1 | | | | | | | | | |
| | | | 2.2.2 | | | | | | | | | |
| | | | 2.2.3 | | | | | | | | | |
| | | 2.3. Тусгай зориулалтаар агнах, барих (соёл, шинжлэх ухаан, тусгай төлбөртэй) | 2.3.1 | | | | | | | | | |
| | | | 2.3.2 | | | | | | | | | |
| | | | 2.3.3 | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | *Нийт:* | |
| 3 | Газар | 3.1. Хөдөө аж ахуйн газар | 3.1.1 | | | | | | | | | |
| | | | 3.1.2 | | | | | | | | | |
| | | | 3.1.3 | | | | | | | | | |
| | | 3.2. Хот, тосгон, бусад суурины газар | 3.2.1 | | | | | | | | | |
| | | | 3.2.2 | | | | | | | | | |
| | | | 3.2.3 | | | | | | | | | |
| | | 3.3. Зам, шугам сүлжээний газар | 3.3.1 | | | | | | | | | |
| | | | 3.3.2 | | | | | | | | | |
| | | | 3.3.3 | | | | | | | | | |
| | | 3.4. Ойн сан бүхий газар | 3.4.1 | | | | | | | | | |
| | | | 3.4.2 | | | | | | | | | |
| | | | 3.4.3 | | | | | | | | | |
| | | 3.5. Усны сан бүхий газар | 3.5.1 | | | | | | | | | |
| | | | 3.5.2 | | | | | | | | | |
| | | | 3.5.3 | | | | | | | | | |
| | | 3.6. Тусгай хэрэгцээний газар | 3.6.1 | | | | | | | | | |
| | | | 3.6.2 | | | | | | | | | |
| | | | 3.6.3 | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | *Нийт:* | |
| 4 | Ой | 4.1. Аливаа зориулалтаар ойгоос бэлтгэж ашиглах бүх төрлийн хэрэглээний мод, түлээ | 4.1.1 | | | | | | | | | |
| | | | 4.1.2 | | | | | | | | | |
| | | | 4.1.3 | | | | | | | | | |
| | | | 4.1.4 | | | | | | | | | |
| | | 4.2. Ойн дагалт баялгийн нөөц самар, мөөг, давирхай, шилмүүс, мөчир, үр, хусны шүүс, жимс | 4.2.1 | | | | | | | | | |
| | | | 4.2.2 | | | | | | | | | |
| | | | 4.2.3 | | | | | | | | | |
| | | | 4.2.4 | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | *Нийт:* | |
| 5 | Ус, рашаан | 5.1. Унд ахуйн хэрэгцээний ус, рашаан | 5.1.1 | | | | | | | | | |
| | | | 5.1.2 | | | | | | | | | |
| | | | 5.1.3 | | | | | | | | | |
| | | | 5.1.4 | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | *Нийт:* | |
| СУМ, ДҮҮРГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН НИЙТ ДҮН: | | | | | | | | | | | | |

Бэлтгэсэн: ................................... /Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн/
.................................. /Сум дундын ойн ангийн мэргэжилтэн/
.................................. /Усны сав газрын захиргааны мэргэжилтэн/
.................................. /Татварын улсын байцаагч/
.................................. /Байгаль орчны хяналтын улсын байцаагч/

Хянасан: .................................... /БОАЖГ-ын дарга/

20... оны ... -р сарын ... -ны өдөр

Зөвшөөрсөн: ..................................... /Сум, дүүргийн Засаг дарга/

# Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын 2 дугаар хавсралт

Маягт БНАТ-2

................................ АЙМГИЙН / НИЙСЛЭЛИЙН................................ СУМЫН / ДҮҮРГИЙН ......... ОНД СУМЫН / ДҮҮРГИЙН ТӨСВИЙН БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ХЭСГЭЭР САНХҮҮЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГТГЭЛ ТӨЛӨВЛӨГӨӨ

**Санамж:** Сум, дүүргийн Засаг дарга жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор Байгаль орчныг хамгаалах төсөв, зардлын мэдээллийн санд байршуулж, тухайн шатны төсвийн төсөлд тусгана.

1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ХЭСЭГ

| № | А | Байгалийн ургамал | Ан амьтан | Газар | Ой | Ус, рашаан | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Төвлөрүүлэх төлбөрийн орлого, төгрөгөөр | | | | | | |
| 2 | БОХНСАХ-ний зардалд, төгрөгөөр | | | | | | |
| 3 | БНАТТХ-ийн 18.1-д заасан хувиар | 15% ≤ (........) | 50% ≤ (........) | 15% ≤ (........) | 85% ≤ (........) | 35% ≤ (........) | (........) |
| 4 | Тухайн онд үүссэн дараа онд зарцуулах давсан орлого, төгрөгөөр | | | | | | |
| 5 | Дараа онд зарцуулах давсан орлогын хэсэг, төгрөгөөр | | | | | | |
| 6 | БНАТТХ-ийн 18.1-д заасан хувиар | 15% ≤ (........) | 50% ≤ (........) | 15% ≤ (........) | 85% ≤ (........) | 35% ≤ (........) | (........) |
| 7 | Дараа онд хамаарах БНАТ-ийн нийт орлого, төгрөгөөр | | | | | | |
| 8 | Нийт БОХНСАХ-ний зардал, төгрөгөөр | | | | | | |
| 9 | **Хуулийн хэрэгжилт, хувиар** | | | | | | |

2. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ ХЭСЭГ

| № | Нөөц | Хэрэгжүүлэх арга хэмжээ | | Байршил | Арга хэмжээг төлөвлөх үндэслэл | | | | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | | | | Хариуцагч | Санхүүгийн мэдээлэл | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Менежментийн төлөвлөгөө | ИТХ-ын тогтоол | ЗДҮА-ны хөтөлбөр | Бусад | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх үр дүн | Хугацаа | | Хэмжих нэгж | Төлөвлөсөн тоо хэмжээ | Нэгжийн төсөвт өртөг | Нийт төсөвт өртөг, төгрөгөөр |
| | А | Б | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 |
| 1 | Байгалийн ургамал | 1.1 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.2 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.3 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.4 | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | Нийт: | |
| 2 | Ан амьтан | 1.1 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.2 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.3 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.4 | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | Нийт: | |
| 3 | Газар | 1.1 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.2 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.3 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.4 | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | Нийт: | |
| 4 | Ой | 1.1 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.2 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.3 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.4 | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | Нийт: | |
| 5 | Ус, рашаан | 1.1 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.2 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.3 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.4 | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | Нийт: | |
| | | | | | | | | | | | | | | | | НИЙТ ДҮН: | |

Бэлтгэсэн: ................................ /Байгаль орчны хяналтын улсын байцаагч/

Хянасан: ............................ /БОАЖГ-ын дарга/

Зөвшөөрсөн: ............................. /Сум, дүүргийн Засаг дарга/

20... оны ... -р сарын ... -ны өдөр

# Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын 3 дугаар хавсралт

Маягт БНАТ-2-А

............................... АЙМГИЙН / НИЙСЛЭЛИЙН............................... СУМЫН / ДҮҮРГИЙН ......... ОНЫ ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ХЭСГЭЭР САНХҮҮЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ХЭСЭГ

| № | А | Байгалийн ургамал | Ан амьтан | Газар | Ой | Ус, рашаан | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Төвлөрүүлэх төлбөрийн орлого, төгрөгөөр | | | | | | |
| 2 | БОХНСАХ-ний зардалд, төгрөгөөр | | | | | | |
| 3 | БНАТТХ-ийн 18.1-д заасан хувиар | 15% ≤ (........) | 50% ≤ (........) | 15% ≤ (........) | 85% ≤ (........) | 35% ≤ (........) | (........) |

**Санамж:** Сум, дүүргийн байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, усны сав газрын захиргаа, сум дундын ойн анги, төрийн сангийн мэргэжилтэн, сум, дүүргийн газрын даамал нар хамтран боловсруулна. Жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор Байгаль орчныг хамгаалах төсөв, зардлын мэдээллийн санд байршуулж, аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагад маягтаар хүргүүлнэ.

2. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ ХЭСЭГ

| № | Нөөц | Хэрэгжүүлэх арга хэмжээ | | Байршил | Арга хэмжээг төлөвлөх үндэслэл | | | | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | | | | Хариуцагч | Санхүүгийн мэдээлэл | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Менежментийн төлөвлөгөө | ИТХ-ын тогтоол | ЗДҮА-ны хөтөлбөр | Бусад | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх үр дүн | Хугацаа | | Хэмжих нэгж | Төлөвлөсөн тоо хэмжээ | Нэгжийн төсөвт өртөг | Нийт төсөвт өртөг, төгрөгөөр |
| | А | Б | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 |
| 1 | Байгалийн ургамал | 1.1 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.2 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.3 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.4 | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | *Нийт:* | |
| 2 | Ан амьтан | 1.1 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.2 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.3 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.4 | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | *Нийт:* | |
| 3 | Газар | 1.1 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.2 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.3 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.4 | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | *Нийт:* | |
| 4 | Ой | 1.1 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.2 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.3 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.4 | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | *Нийт:* | |
| 5 | Ус, рашаан | 1.1 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.2 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.3 | | | | | | | | | | | | | | | |
| | | 1.4 | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | *Нийт:* | |
| | | | | | | | | | | | | | | | | НИЙТ ДҮН: | |

Бэлтгэсэн: ............................... /Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн/
........................................... /Сум дундын ойн ангийн мэргэжилтэн/
........................................... Усны сав газрын захиргааны мэргэжилтэн/
........................................... /Төрийн сангийн мэргэжилтэн/
........................................... /Байгаль орчны хяналтын улсын байцаагч/

Хянасан: ........................... /БОАЖГ-ын дарга/

Зөвшөөрсөн: ............................ /Сум, дүүргийн Засаг дарга/

20... оны ... -р сарын ... -ны өдөр

# Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын 4 дүгээр хавсралт

Маягт БНАТ-2-Б

................................ АЙМГИЙН / НИЙСЛЭЛИЙН................................ СУМЫН / ДҮҮРГИЙН ......... ОНЫ ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ДАВСАН ОРЛОГЫН ХЭСГЭЭР ........ ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| 1 | Төлбөрийн орлого, төгрөгөөр | | | | | | | | | | | | |
| 2 | БОХНСАХ-нд тусгах зардал, төгрөгөөр | | | | | | | | | | | | |
| 3 | БОХНСАХ-нд тусгах зардал, хувиар | | | | | | | | | | | | |
| 4 | Давсан орлого, төгрөгөөр | | | | | | | | | | | | |
| 5 | Давсан орлогын хэсэг, төгрөгөөр | | | | | | | | | | | | |
| 6 | БОХНСАХ-нд тусгах зардал, хувиар | | | | | | | | | | | | |
| 7 | БНАТ-ийн нийт орлого, төгрөгөөр | | | | | | | | | | | | |
| 8 | Нийт БОХНСАХ-нд тусгах зардал, төгрөгөөр | | | | | | | | | | | | |
| 9 | **Хуулийн хэрэгжилт, хувиар** | | | | | | | | | | | | |

2. БОХНСАХ-НИЙ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГТГЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

| № | Нөөц | | Үйл ажиллагааны чиглэл | Хэрэгжүүлэх сум | Арга хэмжээний тоо | Зарцуулалтын төлөвлөгөө | Зарцуулсан дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | А | Б | В | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Байгалийн | 1 | Нэн ховор, ховор, ашигт ургамлыг хамгаалах, таримлуулах санаачлагыг дэмжих | | | | |
| | | 1 | Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх | | | | |
| | | | *Нийт :* | | | | |
| 2 | Ан амьтан | 2 | Судалгаа | | | | |
| | | 2 | Амьтдын амьдрах орчныг сайжруулах, хамгаалах | | | | |
| | | | *Нийт :* | | | | |
| 3 | Газар | 3 | Судалгаа | | | | |
| | | 3 | Нөхөн сэргээлт | | | | |
| | | | *Нийт :* | | | | |
| 4 | Ой | 4 | Судалгаа | | | | |
| | | 4 | Ой хамгаалал | | | | |
| | | 4 | Ойн нөхөн сэргээлт | | | | |
| | | | *Нийт :* | | | | |
| 5 | Ус, рашаан | 5 | Усан сан, гол мөрний урсац бүрэлдэх эхийг хамгаалах | | | | |
| | | 5 | Усан сан бүхий хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх | | | | |
| | | 5 | Усны нөөц бохирдлоос хамгаалах, бохирдлыг бууруулах | | | | |
| | | 5 | Усны экосистемийг тэтгэх | | | | |
| | | | *Нийт :* | | | | |
| 6 | Нийтлэг | 6 | Орон нутгийн хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулах | | | | |
| | | 6 | Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулах | | | | |
| | | | *Нийт :* | | | | |
| | | | | | НИЙТ ДҮН: | | |

Боловсруулсан:................................................ /Ахлах Мэргэжилтэн/

Хянасан:........................................... /Аймгийн БОАЖГ-ын дарга/

20... оны ... -р сарын ... -ны өдөр

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2022 оны 06 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 01 | Улаанбаатар хот

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн талаарх зохицуулалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг дахин хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 15.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Н.Чинбат даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Одбаяр, Ш.Солонго, Б.Буяндэлгэр /илтгэгч/, Г.Туулхүү, Ц.Нанзаддорж, Г.Баясгалан, Ж.Эрдэнэбулган, Д.Гангабаатар нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Т.Доржханд, Д.Үүрцайх болон Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нар оролцов.

Энэхүү хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн талаарх зохицуулалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу дахин хянан хэлэлцэв.

***Нэг. Монгол Улсын иргэн Т.Доржханд, Д.Үүрцайх нар Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээлэл, нэмэлт тайлбар гаргасан байна. Үүнд:***

“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлүүдээс үзэхэд хэд хэдэн Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 05 дугаар дүгнэлтэд үндэслэн Үндсэн хуулиар сонгуулийн тогтолцоог зөвхөн олонхийн тогтолцоо байхаар тогтоосон гэсэн төөрөгдлийг үүсгэсэн үг, мэдэгдлийг олонтаа гаргасан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 05 дугаар дүгнэлтээрээ Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан /эдүгээ хүчин төгөлдөр бус болсон/ Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад "хувь тэнцүүлсэн /пропорциональ/;", 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэгт "Улсын Их Хурлын 48-аас илүүгүй гишүүнийг олонхийн сонгуулиар, 28-аас илүүгүй гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар тус тус сонгоно." гэж заасны "... 28-аас илүүгүй гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар ..." гэж заасан нь Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд ... шууд ... сонгоно.", Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно." гэснийг тус тус зөрчсөн байна." хэмээн шийдвэрлэжээ.

Дээрх дүгнэлтийн үндэслэлд сонгох эрхийн шууд байх зарчмыг "... аль нэг намд бус нэр дэвшигч иргэнд өөрт нь саналаа өгөх замаар Улсын Их Хурлын гишүүнийг сонгох агуулгаар хуульчилсан ...", "... ямар нэг байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр дамжуулан дам сонгохгүйгээр, сонгогч саналаа аливаа этгээдээр төлөөлүүлэхгүйгээр өөрөө биечлэн, шууд гарган сонгохыг ойлгоно. ..." хэмээн дэлхийн аль ч улсын үндсэн хуулийн эрх зүйн онол сургаалд урьд өмнө дурдагдаж байгаагүй агуулгаар тайлбарласан. Ийнхүү тайлбарласан нь Үндсэн хуулийн Удиртгал хэсэгт "... хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх ..." гэж тодорхойлогдсон Монголын ард түмний эрхэм зорилго, Үндсэн хуулийн суурь зарчим, үзэл санаатай нийцэхгүй юм.

Гэтэл Монгол Улсын Их Хурал 2016 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 38 дугаар тогтоолоороо магадгүй улс төрийн хуйвалдаан, тохиролцооны улмаас Үндсэн хуулийн суурь үзэл санааг илэрхий буруу тайлбарласан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 05 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрч энэхүү дүгнэлтийг дэмжсэн эсэх, тухайн дунд суудлын хуралдаанд оролцоогүй дөрвөн гишүүн үүнийг хэрхэн шийдвэрлэх байсан эсэхийг тогтоох боломж буюу Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар уг Үндсэн хуулийн маргааныг эцэслэн шийдвэрлэх боломжийг олгоогүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 38 дугаар тогтоолд үндэслэн тухайн үеийн Сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтууд, мөн 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг зэргийг батлах явцад сонгуулийн олонхийн тогтолцоог л Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэц хүлээн зөвшөөрнө гэсэн эрх зүйн төөрөгдөлд хууль тогтоогчид буюу Улсын Их Хурлын гишүүд хөтлөгдсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Харин "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай" Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар дүгнэлт болон "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай" Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 03 дугаар тогтоолоор Улсын Их Хурлыг сонгон байгуулахад хувь тэнцүүлэх сонгуулийн тогтолцоо Үндсэн хуулиар зөвшөөрөгдсөн болохыг Үндсэн хуулийн цэц тогтоосон байна.

Нөгөө талаас 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр энэхүү асуудалтай холбогдсон шинэ учир байдал үүссэн буюу Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт тодорхой нэмэлт, өөрчлөлт орж, "Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. ..." гэсэн заалт батлагдсан. Энэхүү заалтын "журам" гэдэгт сонгуулийн тогтолцоо бүхэлдээ илэрхийлэгдэж байгаа гэж үзэж болох бөгөөд хууль тогтоогч эдүгээ сонгуулийн хувь тэнцүүлэн сонгох, холимог, хосолсон тогтолцооны хувилбаруудаас сонгон хэрэглэж болох бүрэн эрх нь нээгдсэн гэж үзэх нөхцөл байдал үүссэн гэж би хувьдаа үзэж байна. Харамсалтай нь Үндсэн хуулийн цэцийн дээр дурдагдсан салаа утга бүхий, эсрэг тэсрэг шийдвэрүүдийн улмаас хууль тогтоох байгууллагад болон нийгэмд эргэлзээ тээнэгэлзэл, эрх зүйн тодорхойгүй байдал үүсэж сонгуулийн тогтолцоог дэлхийн парламентын ардчилалтай улсуудын сайн жишигт нийцүүлэн сонгон хуульчлах боломж нөхцөл хязгаарлагдаад байна.

Монгол Улсын Үндсэн хуулийг анх 1992 онд батлах үед Улсын Их Хурлын 76 гишүүнийг тухайн үеийн сонгуулийн насны иргэдийн тоонд үндэслэн харьцуулж нэг гишүүн 15-20 мянган сонгогчийг төлөөлнө гэсэн зарчмаар оруулсан байдаг. 1992 онд 2.1 сая хүн амтай байсан бол өдгөө 3.3 сая хүн амтай болж 1 гишүүн дунджаар 42.7 мянган хүн амыг төлөөлөх болсон байна. Тиймээс судлаачид Улсын Их Хурлын гишүүдийн тоог хүн амын тоотой уялдуулан, төлөөллийн зарчмыг илүү сайн хангуулах үүднээс нэмэх, цаашид Үндсэн хуулийн хүрээнд уг асуудлыг авч үзэх

бодит шаардлага бий болсон гэж үздэг. Сонгогчдын тоо 2-3 дахин өссөн өнөөгийн нөхцөлд төлөөллийн зарчим хангагдахгүй байдалд хүрч, хэт олон сонгогчийг нэг гишүүн төлөөлөх нь төр, иргэний хоорондын эргэх холбоог ч алдагдуулна. Үндсэн хуулийн суурь үзэл санаа, зарчмаар нөхцөлдөж буй эдгээр шаардлагуудыг гишүүдийн тоог нэмэгдүүлснээр хангах боломжтой бөгөөд сонгуулийн тогтолцооны сонголт болон сонгох эрхийн баталгааг хангахад энэ нөхцөлийг анхааран үзэх ёстой.

Иймд Үндсэн хуулийн цэцийн шийдвэрүүдийн зөрчилтэй агуулгыг нэг мөр болгож, эрх зүйн тогтвортой, тодорхой байдал үүсгэхийн тулд маргааныг дахин хэлэлцэж, эцэслэн шийдвэрлэж өгнө үү.” гэжээ.

***Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Үндсэн хуулийн цэцэд дараах агуулгатай тайлбарыг ирүүлжээ. Үүнд:***

“1.Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар дүгнэлт, 03 дугаар тогтоол, 2016 оны 05 дугаар дүгнэлттэй холбоотойгоор сонгуулийн тогтолцоог Улсын Их Хурал шийдвэрлэхэд хүндрэлтэй асуудал үүссэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа билээ. Үндсэн хуулийн цэцийн хяналтыг дээд хяналт гэдгийн учир нь Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг давж заалдах, хяналтын журмаар дахин хянах, өөрчлөх, хүчингүй болгох эрх бүхий байгууллага, албан тушаалтан байдаггүйд оршино. Өөрөөр хэлбэл, Цэцийн шийдвэр гармагцаа хуулийн хүчин төгөлдөр болж биелэгдэх хүчин чадалтай, тухайн асуудлаар цаашид нийтээр дагаж мөрдөх, удаан хугацаанд үйлчлэх жишиг тогтоох хандлагатай байдгаараа бусад байгууллагын шийдвэрээс ялгаатай, мөн тэр хэрээр иргэд болон албан тушаалтан, нийт нийгэмд нөлөөлөл ихтэй байдаг билээ.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “... Хэрэв эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргахдаа Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль болон бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээвэл Цэцийн аль нэг гишүүний санаачилгаар Цэц хяналтын журмаар хянан шийдвэрлэж болно.” гэж заасан. Энэ агуулгаараа Цэц санаачилгаараа маргаан үүсгэж байгаа биш, урьд эрх

бүхий субьектийн гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлт бүхий үүссэн маргааныг Үндсэн хуулийг хамгаалах чиг үүргийнхээ дагуу дахин хянаж байгаа ажиллагаа гэж үздэг.

Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг биелүүлээгүй, эсвэл хууль зүйн хувьд бүрэн биелүүлэхгүйгээр хэлбэрийн төдийд хэрэгжүүлэх, ташаа ойлгож мушгин гуйвуулсан бол тухайн шийдвэрийн хууль зүйн үр нөлөө, нийгэмд гүйцэтгэх үүрэг тодорхой хэмжээнд буурах, эрх зүйн хийдэл үүсэх зэрэг сөрөг үр дагавартай гэж үздэг учраас Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн хүрээнд сонгуулийн хууль тогтоомжийг батлан гаргахдаа дүгнэлтэд дурдсан асуудлыг агуулгаар нь сэргээлгүй, Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль дээдлэх төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг баримталсан болно.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2012 оны 02 дугаар дүгнэлт болон 03 дугаар тогтоолдоо сонгуулийн холимог тогтолцоо нь Үндсэн хуулийг ялангуяа шууд сонгох эрхийг зөрчсөн гэсэн шийдвэр гаргаагүй, харин дүн гаргахад санал шилжүүлэх зохицуулалтыг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, 2012 оны сонгуулийг мажоритар болон пропорциональ буюу хувь тэнцүүлэх тогтолцоог хослуулан хосолмол тогтолцоогоор явуулж, Улсын Их Хурлын 76 гишүүний 48-ыг нь мажоритар тогтолцоогоор буюу олон мандаттай томсгосон тойргоос, үлдсэн 28-ыг нь нам, эвслийн төлөө санал өгч пропорционалиар сонгосон.

Харин Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2016 оны 05 дугаар дүгнэлтдээ Улсын Их Хурлын сонгуулийг хувь тэнцүүлсэн элемент бүхий тогтолцоогоор явуулах боломжийг хаасан үр дагавар үүсгэсэн гэж үздэг. Үндсэн хуулийн цэц дээрх дүгнэлтийг гаргахдаа тэр үеийн Ардын Их Хурлын чуулган дээр санал хураалгасан томьёоллыг бус Улсын Бага Хурлын чуулганы хуралдаан дээр санал хураалгасан томьёоллыг барьсан нь үндэслэл бүхий шийдвэр гаргасанд эргэлзээ төрүүлдэг бөгөөд Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэлээс харахад тусгайлан сонгуулийн тогтолцооны талаар санал хураагаагүй байна /1991.12.04/.

Мөн 2019 оны Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн төслийг улс төрийн намуудаар хэлэлцүүлэх үед болон хожим Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг улс төрийн намуудаар хэлэлцүүлэх үед ч мөн л Улсын Их Хурлын сонгуулийг холимог, эсхүл сонгуулийн хувь тэнцүүлсэн /пропорциональ/ тогтолцоогоор

явуулах асуудлыг Үндсэн хуулиар зохицуулах нь зүйтэй гэсэн санал удаа дараа ирж байсан.

Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны шинэчлэлийг парламентын ардчилал, улс төрийн намуудын төлөвшлийг дагаж, байнгын хөгжил хөдөлгөөнд авч үзэх нь зайлшгүй ба 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийхдээ төрийн эрх мэдлийн хяналт, тэнцлийг хангах, парламентын ардчиллыг хөгжүүлэх, ард түмний засаглах эрхийг хангах, төрийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор сонгуулийн тогтолцоог сайжруулах, боловсронгуй болгох, Улсын Их Хурлын гишүүний тоог нэмэгдүүлэх, үүнтэй уялдуулан Улсын Их Хурлын гишүүний албыг давхар хашиж байгаа Засгийн газрын гишүүний тоонд тавих хязгаарыг авч үзэх талаар хэлэлцүүлгийн үед саналууд гарч байсан.

Энэ хүрээнд 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн төслийг өргөн мэдүүлэхэд Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсгийг “4.Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо, журмыг хуулиар тогтооно. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.” гэж өөрчлөн найруулахаар тусгасан байсан боловч хэлэлцүүлгийн явцад хэд хэдэн саналын хувилбар гарч хэлэлцэгдэн улмаар “... сонгуулийн журмыг хуулиар тогтооно. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.” гэсэн заалтаар эцэслэн баталж сонгуулийн хуулийн талаарх эрх зүйн шинэ орчин бүрдсэн болно.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлж эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх шаардлагын хүрээнд хоёрдмол агуулга бүхий хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар дүгнэлт, 03 дугаар тогтоол, 2016 оны 05 дугаар дүгнэлт, Улсын Их Хурлын 2016 оны 38 дугаар тогтоолыг хэлэлцэн хүчингүй болгох шаардлага тулгараад байна.

Үндсэн хуулийн цэцийн дээр дурдсан хоёр өөр агуулга бүхий шийдвэрийг Үндсэн хуулийн цэц эцэслэн шийдвэрлэсэн тохиолдолд Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ дагуу сонгуулийн тогтолцооны асуудлыг сонгох боломжтой болохыг энэ дашрамд дурдах нь зүйтэй.

Иймд Үндсэн хуулийн цэц дээрх өөр хоорондоо зөрчилтэй Үндсэн хуулийн цэцийн болон Улсын Их Хурлын шийдвэрийг эцэслэн шийдвэрлэхийг хүсье.” гэсэн байна.

***Гурав. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар дүгнэлтийн үндэслэх хэсэгт:***

“1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох хэсгийн зохицуулалт нь Улсын Их Хурлын сонгуулийн 26 тойрогт 48 мандатын төлөө нэр дэвшигчдээс тус тусын тойрогтоо ялагдал хүлээсэн боловч тэдгээрээс 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох боломжийг бий болгон хуульчилснаараа зарим нэр дэвшигч нарт давуу байдал бий болгон Үндсэн хуульд заасан хуулийн өмнө эрх тэгш байх зарчмын агуулгыг алдагдуулсан байна.

2.Түүнчлэн сонгуулийн эрх бүхий иргэд нэгэнт сонголтоо хийсэн байтал дээрх зохицуулалт нь Улсын Их Хурлын 26 тойрогт нэр дэвшээд тус тусын тойрогт ялагдал хүлээсэн боловч 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигч улс төрийн нам, эвслийн жагсаалтад шилжин орсноор Улсын Их Хурлын гишүүний мандат буюу суудлыг нам, эвсэлд тэдгээрийн авсан саналын хувь хэмжээгээр хуваарилах агуулгатай сонгуулийн хувь тэнцүүлэх хэлбэр хэрэгжих боломжгүйд хүрч, улмаар иргэдийн шууд сонгох эрхийг алдагдуулсан байна.

3.Мөн Улсын Их Хуралд нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчид өгсөн санал хоёр удаа буюу сонгуулийн олонхийн болон хувь тэнцүүлэх хэлбэрт тус тус үнэлэгдсэнээр, намын нэрээр өгсөн сонгогчдын санал эзэнгүйдэн, улс төрийн нам, намуудын сонгуулийн эвслийн жагсаалтад орсон 28 нэр дэвшигчид өгсөн саналыг бодитойгоор үнэлэх боломжгүй байдалд хүргэн, тэдгээрийн сонгогдох эрхийг хязгаарласан байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох хэсгийн зохицуулалт нь дээр

дурдсан зөрчлийн шинжийг агуулснаараа ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал, засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байх Үндсэн хуулийн суурь зарчимд харшилсан байна.” ***гээд уг дүгнэлтийн дүгнэлт гаргах хэсэгт:***

“1.Улсын Их Хурлын сонгуулийн 26 тойрогт 48 мандатын төлөө нэр дэвшигчдээс тус тусын тойрогтоо ялагдал хүлээсэн боловч тэдгээрээс 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох боломжийг бий болгон хуульчилсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсэгт “... энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан ...”, 49 дүгээр зүйлийн 49.1.5 дахь заалтад “энэ хуулийн 48.2-т заасан “А” жагсаалтаас дараах нэр дэвшигчдийг хасаж, хасагдсан нэр дэвшигчдийн авсан саналын хувиудын нийлбэрийг тухайн жагсаалтад үлдсэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигчдээс бусад нэр дэвшигчид тэнцүү хуваан шилжүүлэн нэмж жагсаалт /цаашид “В” жагсаалт” гэх/-ыг гаргах:”, 49.1.5.а заалтад “санал өгсөн сонгогчдын 28-аас доош хувийн санал авсан нэр дэвшигч;”, 49.1.5.б заалтад “санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бие даан нэр дэвшигч;”, 49.1.5.в заалтад “санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бөгөөд улсын хэмжээнд таваас доош хувийн санал авсан нам, эвслээс нэр дэвшигч.”, 49.1.6 дахь заалтад “тойрог бүрээр гаргасан 49.1.5-д заасан “В” жагсаалтад орсон, энэ хуулийн 48.2, 48.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчдийг нам, эвсэл бүрээр нь, “В” жагсаалт дахь авсан саналын хувиар нь дараалалд оруулах ба тэдгээр нэр дэвшигчдийн дараа ...” гэж заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж ... сонгоно.” гэснийг тус тус зөрчсөн байна. …” гэжээ.

***Дөрөв.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 03 дугаар тогтоолын үндэслэх хэсэгт:***

“1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох хэсгийн зохицуулалт нь Улсын Их Хурлын сонгуулийн 26 тойрогт 48 мандатын төлөө нэр дэвшигчдээс тус тусын тойрогтоо ялагдал хүлээсэн боловч тэдгээрээс 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох боломжийг олгож байгаагаараа зарим нэр дэвшигч нарт давуу байдал бий болгон Үндсэн хуульд заасан хуулийн өмнө эрх тэгш байх болон сонгуулийн шууд сонгох зарчмын агуулгыг алдагдуулсан байна.

2.Мөн Улсын Их Хуралд нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчид өгсөн санал хоёр удаа буюу сонгуулийн олонхийн болон хувь тэнцүүлэх хэлбэрт тус тус үнэлэгдсэнээр, намын нэрээр өгсөн сонгогчдын санал эзэнгүйдэн улс төрийн нам, намуудын сонгуулийн эвслийн жагсаалтад орсон 28 нэр дэвшигчид өгсөн саналыг бодитойгоор үнэлэх боломжгүй байдалд хүргэн иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хязгаарласан байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох хэсгийн зохицуулалт нь дээр дурдсан зөрчлийн шинжийг агуулснаараа ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал, засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байх Үндсэн хуулийн суурь зарчимд харшилсан байна.

3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гуравдугаар зүйлийн 1, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, Арван зургадугаар зүйлийн 9, Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчсөн гэж үзсэн Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.” ***гээд уг дүгнэлтийн тогтоох хэсэгт:***

“1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсэгт “... энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан ...”, 49 дүгээр зүйлийн 49.1.5 дахь заалтад “энэ хуулийн 48.2-т заасан “А” жагсаалтаас дараах нэр дэвшигчдийг хасаж, хасагдсан нэр дэвшигчдийн авсан саналын хувиудын нийлбэрийг тухайн жагсаалтад үлдсэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигчдээс бусад нэр дэвшигчид тэнцүү хуваан шилжүүлэн нэмж жагсаалт /цаашид “В” жагсаалт” гэх/-ыг гаргах:”, 49.1.5.а заалтад “санал өгсөн сонгогчдын 28-аас доош хувийн санал авсан нэр дэвшигч;”, 49.1.5.б заалтад “санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бие даан нэр дэвшигч;”, 49.1.5.в заалтад “санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бөгөөд улсын хэмжээнд тавааc доош хувийн санал авсан нам, эвслээс нэр дэвшигч.”, 49.1.6 дахь заалтад “тойрог бүрээр гаргасан 49.1.5-д заасан “В” жагсаалтад орсон, энэ хуулийн 48.2, 48.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчдийг нам, эвсэл бүрээр нь, “В” жагсаалт дахь авсан саналын хувиар нь дараалалд оруулах ба тэдгээр нэр дэвшигчдийн дараа...” гэж заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж... сонгоно.” гэснийг тус тус зөрчсөн байх тул Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дээрх заалтуудыг хүчингүй болгосугай.

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.5.в заалтад хамаарах “Тайлбар: Энэ хуулийн 48.5-д заасны дагуу дахин санал хураалтад орсон боловч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчийн “В” жагсаалт дахь өөрийн авсан саналын хувь нь анхны санал хураалтын саналын хувь байна.” гэснийг хүчингүй болгосугай.

3.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 2012 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 26 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай. ...” гэсэн байна.

***Тав. Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 05 дугаар дүгнэлтийн үндэслэх хэсэгт:***

“1.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн үзэл баримтлалыг тодорхой болгох үүднээс Үндсэн хуулийн төслийг хэлэлцсэн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын болон Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэлийг судлан үзэхэд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын хуралдаанаар Улсын Их Хурлыг бүрдүүлэхэд хэрэглэх сонгуулийн хэлбэрийн талаар хэлэлцэж санал хураалт явуулж байжээ.

Тодруулбал, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын Үндсэн хуулийн төслийг хэлэлцсэн 1991 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанд зарим гишүүний гаргасан саналын дагуу “... Их Хурлын гишүүдийн заримыг нь намын талаар авсан саналын үндсэн дээр хувь тэнцүүлэн суулгах, заримыг нь тухайлбал, гуравны хоёрыг нь шууд сонгож бүрдүүлэх гэсэн ийм холимог бүрэлдэхүүнтэй байх. Нэг танхимтай холимог бүрэлдэхүүнтэй парламент байх хэрэгтэй гэсэн. Ийм саналыг дэмжиж байгаа дээр санал хураалт явуулъя ...” гэж хувь тэнцүүлэх элемент бүхий сонгуулийн холимог хэлбэрийг Улсын Их Хурлын сонгуульд хэрэглэх талаар санал хураахад уг санал гишүүдийн олонхийн дэмжлэг авч чадаагүй байна.

Үүнээс үзэхэд Улсын Их Хурлын сонгуулийг хувь тэнцүүлсэн хэлбэрээр явуулах боломжийг Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрөөгүй гэж үзэх үндэслэлтэй байна.

Энэхүү үзэл баримтлалын дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнийг ... сонгоно.”; мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнээр ... иргэнийг сонгоно.” гэсэн зохицуулалтыг тусгаж, аль нэг намд бус нэр дэвшигч иргэнд өөрт нь саналаа өгөх замаар Улсын Их Хурлын гишүүнийг сонгох агуулгаар хуульчилсан байна.

Иймд Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт нь бүхэлдээ, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсгийн “... 28-аас илүүгүй гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар ... сонгоно.” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн дээр дурдсан заалтыг зөрчсөн гэж үзэхээр байна.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан Улсын Их Хурлын гишүүнийг шууд сонгох зарчим нь Улсын Их Хурлын гишүүнийг ямар нэг байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр дамжуулан дам сонгохгүйгээр, сонгогч саналаа аливаа этгээдээр төлөөлүүлэхгүйгээр өөрөө биечлэн, шууд гарган сонгохыг ойлгоно. Иймээс Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдээс Улсын Их Хурлын гишүүнийг шууд сонгох эрхэд хязгаарлалт хийх боломжгүй байна.

3.Иргэдийн мэдээлэлд дурдсан үндэслэлийн хүрээнд Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.” ***гээд дүгнэлт гаргах хэсэгт:***

“1.Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад “хувь тэнцүүлсэн /пропорциональ/;”, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын 48-аас илүүгүй гишүүнийг олонхийн сонгуулиар, 28-аас илүүгүй гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар тус тус сонгоно.” гэж заасны “... 28-аас илүүгүй гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар ...” гэж заасан нь Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд ... шууд ... сонгоно.”, Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.” гэснийг тус тус зөрчсөн байна.

2.Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад

“хувь тэнцүүлсэн /пропорциональ/;”, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын 48-аас илүүгүй гишүүнийг олонхийн сонгуулиар, 28-аас илүүгүй гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар тус тус сонгоно.” гэж заасан нь Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1, Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй байна. ...” гэжээ.

***Зургаа. Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн Гуравдугаар зүйлийн 2 дахь заалтаар “4.Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.” гэж өөрчлөн найруулжээ.***

**ҮНДЭСЛЭЛ:**

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2012 онд Сонгуулийн тухай хуулийн хувь тэнцүүлсэн тогтолцоонд хамаарал бүхий зохицуулалтын талаарх маргааныг хянан хэлэлцэхдээ холимог тогтолцоогоор Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулах нь Үндсэн хуулийг зөрчсөн талаар тусгайлан дүгнээгүй байна.

Үндсэн хуулийн цэц 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэгт холбогдох маргааныг хянан хэлэлцээд Улсын Их Хурлын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулах талаарх зохицуулалтын хувь тэнцүүлсэн хэлбэрт хамаарах заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “шууд” сонгох зарчим болон мөн зүйлийн 3 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн гэсэн 05 дугаар дүгнэлтийг гаргажээ.

Үүнээс үзэхэд, Үндсэн хуулийн цэцийн 2016 оны дээрх дүгнэлт нь 2012 оны 02 дугаар дүгнэлт, 03 дугаар тогтоолтой зөрчилдсөн байх бөгөөд зарчмын хувьд эсрэг агуулгатай Үндсэн хуулийн цэцийн шийдвэрүүд нэгэн зэрэг хүчин төгөлдөр байна.

2.Улсын Их Хурлын сонгуулийн журмын талаар Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн төслийг хэлэлцсэн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын болон Ардын Их Хурлын

хуралдааны тэмдэглэлийг судлан үзэхэд Үндсэн хууль тогтоогч болох Ардын Их Хурал нь Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо болон сонгуулийн журмыг хуулиар тогтоохоор заасныг баталсан байна.

Үндсэн хуулийн цэц 2016 оны 05 дугаар дүгнэлтдээ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын холбогдох хуралдааны тэмдэглэлийг үндэслэл болгосон байдаг. Уг тэмдэглэлийн агуулгаас үзэхэд Улсын Их Хурлыг бүрдүүлэх сонгуулийн тогтолцооны асуудлыг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын энэхүү хуралдаанаас эцэслэн шийдвэрлэсэн гэж үзэх үндэслэлгүй байх бөгөөд санал хураалт явуулсан процесс нь зөвхөн холимог тогтолцоотой холбоотойгоор явагдаж, энэ талаар Үндсэн хууль тогтоогчид танилцуулж эцэслэн шийдвэрлүүлсэн зүйл үгүй байгааг дурдах нь зүйтэй байна.

Үүнээс үзэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. ...” гэж зааснаар Үндсэн хуулийн үзэл баримтлал, иргэд нийтээрээ, чөлөөтэй, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах сонгуулийн зарчмын хүрээнд Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо, түүний хувилбарыг сонгон тодорхойлох, сонгуулийг зохион байгуулах журмыг хуульчлах бүрэн эрхийг хууль тогтоогчид олгосон байна.

3.Маргагч талууд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн мэдээлэл, нэмэлт тайлбар болон маргаанд холбогдуулан гаргасан тайлбартаа 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсгийг өөрчлөн найруулснаар эрх зүйн шинэ орчин бүрдсэн бөгөөд Үндсэн хуулийн цэцийн өмнө гаргасан шийдвэрүүд, тухайлбал 2012 оны 02 дугаар дүгнэлт, 03 дугаар тогтоол, 2016 оны 05 дугаар дүгнэлттэй холбоотойгоор сонгуулийн тогтолцоог Улсын Их Хурал шийдвэрлэхэд хүндрэлтэй асуудал үүсгэж байгаа талаар тусган тодорхой үндэслэлийг гаргаж, уг асуудлыг Үндсэн хуулийн цэц бүрэн эрхийнхээ хүрээнд эцэслэн шийдвэрлэж өгөхийг хүссэн. Энэ талаар маргагч талууд Үндсэн хуулийн цэцийн хуралдааны явцад тус тусын шаардлага, үндэслэлийг харилцан хүлээн зөвшөөрсөн болно.

4.Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэн батлах хүрээнд Улсын Их Хурлын сонгуулийн журмыг тодорхойлохтой холбоотой зохицуулалт болох Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсгийг өөрчлөн найруулжээ. Ийнхүү өөрчлөн найруулсан нь Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо, түүний хувилбарыг сонгон хуульчлах хууль тогтоогчийн буюу Улсын Их Хурлын бүрэн эрхийг баталгаажуулсан байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 05 дугаар дүгнэлт болон 2012 оны 02 дугаар дүгнэлт, 03 дугаар тогтоолыг хүчингүй болгох үндэслэлтэй байна.

5.Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд гаргасан Үндсэн хуулийн цэцийн энэхүү шийдвэр Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны асуудал нь Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарч байгааг шийдвэрлэсэн эцсийн шийдвэр болохыг тэмдэглэх нь зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 30 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 2, 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:**

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 02 дугаар дүгнэлт болон мөн оны 5 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай” 03 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн “Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 05 дугаар дүгнэлтийг хүчингүй болгосугай.

3.Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

**ДАРГАЛАГЧ** **Н.ЧИНБАТ**

**ГИШҮҮД** **Д.ОДБАЯР**
**Ш.СОЛОНГО**
**Б.БУЯНДЭЛГЭР**
**Г.ТУУЛХҮҮ**
**Ц.НАНЗАДДОРЖ**
**Г.БАЯСГАЛАН**
**Ж.ЭРДЭНЭБУЛГАН**
**Д.ГАНГАБААТАР**

**Хаяг:**
“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn
**Утас:** 262420
Хэвлэлийн хуудас: 3.5
**Индекс: 200003**